

САНГИЙН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны 1. дугаар сарын 10-ны өдөр

№ 3/А/09

Улаанбаатар хот

“Төлбөрийн хэмжээ батлах тухай”

“Эрүүл мэндийн тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 159 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий тавигдах шаардлагыг хангасан хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаар хийлгүүлэх гемодиализ-бөөр орлуулах нэг удаагийн эмчилгээний төлбөрийн хэмжээг 125,000 /нэг зуун хорин таван мянган/ төгрөгөөр баталсугай.

Хоёр. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхтэй холбоотой санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгуулан батлуулж ажиллахыг Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар /Ж.Ганбат/, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газар /Д.Төмөртогтоо/-д тус тус даалгасугай.

Гурав. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар /Н.Нарангэрэл/, Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/ -д тус тус үүрэг болгосугай.

